

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 16

Дугаар № 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Барилга” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны талаархи хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг /цаашид ХЭХ гэх/ 2024 оны 04-р сарын 18-ны өдрийн 14:00 цагт байгууллагын хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хурлаар доорхи асуудлуудыг хэлэлцүүлэх:

- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тайлан
- 2023 оны санхүүгийн тайлан
- Хөндлөнгийн аудитын дүгнэлтийн тухай
- Байгууллагын тайлант оны үр дүн, ашиг хуваарилах тухай
- Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлтгэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай:

Комиссын дарга – Ш.Эрдэнэбат /Гүйцэтгэх захирал/

Гишүүд – Б.Ариунтуяа /Хүний нөөцийн менежер/

Э. Батсүх /Ерөнхий нягтлан бодогч/

4. Комисст даалгах нь:

- Байгууллагын ТУЗ, санхүүгийн болон хөндлөнгийн аудитын дүгнэлт, тайланг бэлтгүүлэх.
- Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны чиглэл, бизнес төлөвлөгөөний гол үзүүлэлтийг бэлтгэж ХЭХ-д оруулах.
- Хурлын зарыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журмын зохих заалтуудын дагуу нийтэд мэдээлэх.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ШАГДАРРАГЧАА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б. АРИУНТУЯА

БАРИЛГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 16

Дугаар № 02

Улаанбаатар хот

Цэвэр ашгийн хуваарилалт ба ногдол ашиг тараах тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Барилга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг тус тус хэлэлцүүлэхээр тогтсугай. Үүнд:
 - 1.1 Цэвэр ашгийн хуваарилалт болон ногдол ашиг тараах тухай
 - 1.2 Саналын эрх бүхий нэгж хувьцаанд ногдох ашгийг 500 төгрөгөөр тогтоож, хуваарилах тухай
 - 1.3 2023 оны ногдол ашгийг “ҮЦТХТ” ХХК-тай байгуулах гэрээний үндсэн дээр 2024 оны 04 сарын 30-ны өдрийн дотор тус төвөөр дамжуулан олгох шийдвэрийн төсөл
 - 1.4 ТУЗ-ийн үр дүнгийн урамшуулал болон төв оффисын ажилтнуудын үр дүнгийн шагналд 8 500 000 /Найман сая таван зуун мянга/ төгрөг олгох санал
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх дээрх асуудлууд, шийдвэрийн төсөл, танилцуулгыг 2024 оны 04 сарын 01-ний өдрийн дотор бэлэн болгохыг Хурал зохион байгуулах комисс /Ш.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ШАГДАРРАГЧАА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б. АРИУНТУЯА